



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 17

Мандагговь

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн
хувь, хэмжээ болон тэмдэгтийн хураамжийн
хувь хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д” дэх заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.31, 21.1.33 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар, ахуйн зориулалтаар шувуу агнах зөвшөөрлийн хураамжийг нэг удаагийн эрхийн бичигт 10000 төгрөгөөр, ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан, барьсан бусад ан амьтны зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 2 хувиар тус тус тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100011